

ОРОН НУТГИЙН СОНИН

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС | 2015 ОНЫ АРАВДУГААР САР



“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИ 20 ОЮУТАНД ТЭТГЭЛЭГ ГАРДУУЛЛАА

10 жилийн хугацаанд 600 гаруй сая төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

(3-р нүүрт)



“ОЮУ ТОЛГОЙ”
КОМПАНИ ЦАХИЛГААН
ДАМЖУУЛАХ ТОМООХОН
ДЭД БҮТЦИЙГ ТӨРИЙН
ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЛЭЭ

(7-р нүүрт)



УЛАМЖЛАЛТ УРЛАЛААСАА
СУРАЛЦАВ

Загасан нуруу хатгах, хөөрөгний
даалин эмжих зэрэг уламжлалт
урлалд 26 хүн суралцсан байна.

(11-р нүүрт)



“ГАЛБЫН ГОВЬ
ЗАЛУУСЫН
ДУРАНД” ГЭРЭЛ
ЗУРГИЙН
УРАЛДААН

(15-р нүүрт)

ХАНБОГД СУМАНД МЭРГЭЖИЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

- 24 суралцагч ажлын байрны мэргэжил, ур чадвар эзэмшинэ -



“Оюу толгой” ХХК-иас санхүүжүүлж, хэрэгжүүлж буй “Мэргэжил олгох хөтөлбөр” 10 дугаар сарын 1-нд нээлтээ хийлээ. Ханбогд сум дахь Техникийн сургалтын төв дээр болсон нээлтийн арга хэмжээнд Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, “Оюу толгой” ХХК-ийн Дэд бүтэц, үйлчилгээ хариуцсан Ерөнхий менежер Эндрью Миллэр болон Ханбогд сумын албаны холбогдох хүмүүс оролцсон юм. Энэ үеэр Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн

“Хөдөлмөрийн яамны зүгээс чадамжид суурилсан сургалтад ач холбогдол өгч байгаа. Энэ ажил орон нутагт бодитойгоор хэрэгжиж байгаад би талархан, хүлээн авч байна. Энэ хөтөлбөр цаашид сургалтын салбарт томоохон жишиг болно гэдэгт эргэлзэхгүй байна” хэмээн хэллээ.

Мөн “Оюу толгой” ХХК-ийн Дэд бүтэц, үйлчилгээ хариуцсан Ерөнхий менежер Эндрью Миллэр “Өмнөговь аймагт чадавхийг



бэхжүүлэх бидний ажил нэг алхам урагшиллаа. Монгол залуус авьяас, чадвартай. Бид хамтран ажилладаг орон нутгийн иргэдийн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжиж, мэдлэг, ур чадварыг нь дэлхийн стандартад хүргэхэд анхаарлаа хандуулж байна” гэж ярих. Эдгээр хүмүүс зургаан сарын хугацаанд цахилгаанчин, гагнуурчин, механикч зэрэг уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарт эрэлт ихтэй мэргэжлээр суралцаж, амжилттай төгсөгчид Австралийн мэргэжил, ур чадварын стандартын гэрчилгээ авах юм.

Сургалтыг “Оюу толгой” ХХК-ийн Мэргэжлийн сургалтын төв, Дорнодын Политехникийн коллеж, Австралийн магадлан итгэмжлэгдсэн байгууллагатай хамтран онол, дадлага хосолсон хэлбэрээр явуулна. Энэ хөтөлбөр “Оюу толгой” компанийн орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмжиж, орон нутгийн ханган нийлүүлэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээ авах зэрэг ажлуудын нэг хэсэг юм.

“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИ 20 ОЮУТАНД ТЭТГЭЛЭГ ГАРДУУЛЛАА

**-10 жилийн хугацаанд 600 гаруй сая төгрөгийн
тэтгэлэг олгоод байна -**



“Оюу толгой” ХХК-иас Өмнөговь аймагт хэрэгжүүлдэг “Говийн тэтгэлэгт хөтөлбөр”-т шалгарсан оюутан залууст батламж гардуулах ёслол 10 дугаар сарын 7-нд болов. Энэ жил тус хөтөлбөрт өмнийн говийн 20 оюутан шалгарчээ.

“Оюу толгой” ХХК үнэт зүйл болох Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэх эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Монголын шилдэг оюутан залуусыг дэмжиж, тэднийг дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцуулах тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг билээ.

“Оюу толгой” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Батсүх ёслолыг нээж хэлэхдээ “Өнөөдөр

өмнийн говийн залуу үеийнхэнд эрдэм боловсрол олгоход нь дэмжлэг үзүүлдэг чухал үйл явдал тохиож байна. “Эдээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим” гэдэг. Та бүхнийг эрдмээр биеэ чимэхэд чинь “Оюу толгой” компани хувь нэмрээ оруулж байна. Орон нутагтаа очиж ажиллаад нутаг орноо хөгжүүлэх явдал бол та нарын ирээдүйн их зорилго шүү. Сайн суралцаж, сайн мэргэжилтэн болоорой ” гэв.

Тэтгэлэгт шалгарсан АУУИС-ийн Нүүр, ам судлалын сургуулийн төгсөх ангийн оюутан Б.Даваажаргал сэтгэгдлээ хэлэхдээ “Миний оюуныг үнэлж, оюунд минь хөрөнгө оруулалт хийж байгаа “Оюу толгой” компанийнхандаа халуун талархлаа илэрхийлж, ажлын их амжилт хүсье. Ирэх онд сургуулиа төгсөөд

орон нутагтаа очиж ард түмнийхээ эрүүл энхийн манаанд зогсох болно” гэлээ.

“Оюу толгой” компани Өмнөговь аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор тус аймагт нэн шаардлагатай мэргэжлээр сурч буй чадварлаг оюутан залуусын боловсролыг дэмжих, төгсөөд орон нутагтаа ирж ажиллах нөхцөлтэй “Говийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2005 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.

Тэтгэлэгт шалгарсан оюутнуудын сургалтын төлбөрийг “Оюу толгой” компани бүрэн дааж, тус компаниас хэрэгжүүлдэг хөгжлийн сургалтуудад хамрагдах, мэргэжил нь таарсан тохиолдолд дадлага хийх боломжоор хангадаг юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Өмнөговь аймгийн 292 оюутан энэ хөтөлбөрт хамрагдаж, тэдэнд 600 гаруй сая төгрөг зарцуулсан байна. Хөтөлбөр нь Өмнөговь аймгийн харьяат, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн гуравдугаар дамжаа, эсвэл төгсөх ангийн оюутан, сурлагын голч дүн нь гурав болон түүнээс дээш байх болзол хангасан байх шалгууртай юм.

ХАНБОГДЫН ШИЛДЭГ ОЮУТНУУД ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦАНА



“Оюу толгой” компанийн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хэрэгжүүлж буй олон төсөл, хөтөлбөрийн нэг бол орон нутгийн оюутан, залуусын боловсролыг дэмжих “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр” юм. Энэхүү хөтөлбөрт хамрагдсан Ханбогд сумын оюутнуудтай 2015-2016 оны хичээлийн жилийн гэрээ байгуулах ёслол 10 дугаар сарын 23-нд Улаанбаатар хотод болов.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Оюуны өргөө Ханбогд” ТББ оюутан, залуучуудынхаа идэвх санаачилгыг өрнүүлэх, хөтөлбөрийнхөө залгамж чанарыг дээшлүүлэх, ахлах ангийн сурагчид, иргэд залуучуудад хөтөлбөрийнхөө үйл ажиллагааг сурталчлах, нийт оюутнуудын

сурч хөгжих эрмэлзлийг дэмжих хүрээнд олон төрлийн ажлыг санаачилан хийж гүйцэтгэж ирсний нэг нь энэхүү “Гэрээ үзэглэх” ёслол юм. Энэхүү ёслолд “Оюу толгой” компанийн Нийгмийн харилцааны хэлтсийн менежер Г.Сугар, тус хөтөлбөрийн зохицуулагч, ахлах мэргэжилтэн Т.Энхтунгалаг, нутгийн хамгийн залуу доктор, МУБИС-ийн Химийн тэнхимийн эрхлэгч Н.Наранцогт, оюутнуудын эцэг эхийн төлөөлөл Н.Биндэрмаа болон Ханбогд сумын ЕБС-ийн урлагийн тэргүүний авъяаслаг сурагч О.Идэрчулуун, Ү.Энхтайван, Б.Азжаргал зэрэг хүмүүс урилгаар оролцлоо.

Энэ үеэр жил бүр уламжлал болон зохиодог оюутнуудын илтгэлийн уралдааны шагналыг гардуулав. Энэ жилийн уралдааныг Б.Наранбаатар захиралтай “Ханбогд хурд” компани ивээн тэтгэсэн бөгөөд тэргүүн байрыг ЭМШУИС-ийн 5-р дамжааны оюутан Б.Агиймаа, дэд байрыг МҮИС-ийн 3-р дамжааны оюутан Г.Цэдэв тус тус эзэлсэн байна. Хөтөлбөрийн оюутнуудаа манлайлан сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан оюутан ЭМШУИС-ийн Дорноговь салбарын 3-р зурсийн оюутан Э.Сайнбуян, Улаанбаатарын их сургуулийн 3-р дамжааны оюутан Н.Батбаяр нар МОЗАУТ-ийн “Оюутны алдар” алтан медалиар шагнуулав.

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК- ИАС ОРОН НУТАГТ ХАНДИВЛАСАН ЭД МАТЕРИАЛЫН МЭДЭЭЛЭЛ

2015 оны 3-р улирал

Ханбогд сум, Улаан Загалмай, гэр 38,000,000

Ханбогд сум, иргэдэд, хаягдал дугуй 5,100

Манлай сум, иргэдэд, хаягдал мод 206,800

Ханбогд сум, иргэдэд, хаягдал мод 1,300,000

Нийт 39.511.900

Мөнгөн дүн төгрөгөөр



ОЮУ ТОЛГОЙН ДАЛД УУРХАЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ФОРУМД

ХАНБОГД СУМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХЫГ УРИАЛЖ БАЙНА



Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Бизнесийн зөвлөл” нь “Оюу толгой” компанитай хамтран ажиллаж, орон нутгийн ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, иргэдийн оролцоог өргөжүүлж ирлээ.

Үүний үр дүнд тус суманд бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, өмнө нь 5-6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдөр 50 гаруй болж нэмэгдсэн юм. Ингэснээр ард иргэдийн орлого нэмэгдэж, амьдралын чанар ч дээшилжээ. Өнөөдөр тус суманд 200-гаад аж ахуйн нэгж албан ёсоор бүртгэлтэй байна. Бид цаашид орон нутгийн ханган нийлүүлэлтийн найдвартай сүлжээ бий болгох зорилготой ажиллаж байна. “Оюу толгой” компани

анх хайгуулын ажлаа эхэлснээс өнөөдрийг хүртэлх Ханбогд болон ойролцоох сумдын хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулжээ. Тухайлбал, “Оюу толгой” компани орон нутгийн тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд 2015 оны эхний есөн сард 1.8 сая ам.долларыг энэ чиглэлд зарцуулжээ.

Үүнээс гадна 2015 оны 3-р улирлын сүүл гэхэд Өмнөговь аймагт бүртгэлтэй 800 гаруй ханган нийлүүлэгч “Оюу толгой” компанид бараа, үйлчилгээ нийлүүлжээ. “Оюу толгой” компани Өмнөговь аймаг дахь худалдан авалтын хэмжээгээ байнга нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ оны 9 сарын байдлаар 44.3 сая ам.доллар болж өсчээ.

Ханбогд сумыг ойрын ирээдүйд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлагдсан бөгөөд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үндэсний болон гадаадын компаниудыг хамтран ажиллахыг

уриалж байна. Энэ ажлын хүрээнд орон сууцны иж бүрэн хорооллууд дэд бүтцийн хамт, аж үйлдвэрийн парк зэрэг бүтээн байгуулалтууд хийгдэх болно.

Энэ дашрамд “Оюу толгой” компанитай хамтран ажилладаг, цаашид хамтран ажиллах компани, аж ахуйн нэгжүүдийг Ханбогд суманд салбар оффис, баазаа нээж ажиллахыг уриалж байна. “Оюу толгой” компанийн үйл ажиллагаа гэрээний дагуу тогтвортой, урт хугацаанд хэрэгжих нь зөвхөн Ханбогд сум төдийгүй нийт Монгол улсын хөгжлийн эрх ашигт зайлшгүй хэрэгтэй юм.

Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Ханбогд сумын “Бизнесийн зөвлөл”-ийн дарга Б.Эрдэнэ-Очир

Б.ХАШ-ЭРДЭНЭ: МАЛЧИД ЦАХИЛГААН ХАЙЧААР ТЭМЭЭГЭЭ НООСЛОХ СОНИРХОЛТОЙ БАЙНА

“Оюу толгой” компанийн жолооч, Ханбогд сумын уугуул Б.Хаш-Эрдэнэ өнгөрсөн онд Австрали улсад цахилгаан хайчаар хонь хяргах сургалтад хамрагдаж, хоёрдугаар зэргийн батламж авсан юм. Тэрээр сургалтаа дүүргэснээс хойш говийн малчдад цахилгаан хайчаар тэмээ ноослох сургалт нэлээд хэдэн удаа явуулжээ. Түүнтэй энэ талаар ярилцлаа.



- Өнгөрсөн зун ямар ажлууд амжуулав?

- Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хүсэлтээр цахилгаан хайчаар тэмээ ноослох сургалтыг 5 дугаар сарын 13, 14-нд Ханхонгор сумын Өгөөмөр баг дээр хийлээ. Манай аймгийн бүх сумын төлөөлөл болох 34 хүн оролцсон байгаа. Энэ сургалт амжилттай болсон. Хүмүүс ч идэвхтэй, сурья гэсэн хүсэл эрмэлзэлтэй байсан.
- **Ханбогд суманд сургалт явуулсан уу?**

- Ханбогд сумын “Говийн баян эрдэнэ” хоршооныхонд сургалт явуулсан. Энэ хоршооныхон долоо хоног айлын тэмээ ноосолсон юм. Бид эхний хоёр өдөрт нь аюулгүй ажиллагаа, машинтайгаа яаж ажиллах, тоног төхөөрөмжөө хэрхэн цэвэрлэх, арчилах талаар заасан. Энэ жилийн хувьд 100 гаруй хүнд сургалт явуулсан тооцоо бий. Миний хувьд сурсан мэдсэнээ нутаг орныхоо хүмүүст хүргэе гэж бодож явдаг.
- **Цахилгаан хайчаар тэмээ ноослох үед анхаарах зүйлүүд байна уу?**
- Олон байгаа. Нэгдүгээрт, өөрийгөө, малаа хамгаалах аюулгүй ажиллагаа чухал, хоёрдугаарт, машинаа цэвэрлэж, арчилах. Наад зах нь машины ирээ хэзээ солих вэ гэдгээ тооцоолох хэрэгтэй. Ир саама ирлээд, боломжтой бол хоёр тэмээ хяргаад соливол сайн.
- **Ханбогд бол манай улсын хамгийн олон тэмээтэй сум. Сумын малчид цахилгаан хайчаар тэмээ ноослох ажлыг сонирхож байна уу?**
- Малчид их сонирхож байна. Цахилгаан хайчаар тэмээ ноослоход нэгдүгээрт, цаг хугацаа хэмнэнэ, хоёрдугаарт, ноосны гарц сайн, гуравдугаарт, малдаа гэмтэл багатай. Говийн халуунд гараар тэмээ ноослох үнэхээр хэцүү

ажил. Малчид цахилгаан хайчаар тэмээгээ ноослох сонирхолтой, сурах хүсэлтэй байгаа. Хүмүүс цахилгаан хайч худалдаж авсан байна. Гэхдээ голдуу өмнөд хөршөөс оруулж ирсэн хайч байна. Би хайчлаад үзсэн. Ажлын бүтээмж багатай юм билээ. Тиймээс сонголтоо зөв хийх хэрэгтэй. Одоо бидний сургалтад хэрэглэж байгаа хайч Австралийнх. Бүтээмж сайтай, хамгийн сүүлийн загвар нь л даа.

- **Малчид тэмээгээ хяргуулах сонирхол байна уу?**
- Дараа жил тэмээгээ хяргуулмаар байна, бичлэгийг нь үзлээ гэсэн малчид олон байна. Ойр орчмын сумын малчид ч асууж, лавлаж байгаа. Миний бодлоор хоршооныхон, эсвэл хэдэн залуу баг болоод цахилгаан хайчаар тэмээ ноослох үйлчилгээ үзүүлэх боломжтой. Хэн хэндээ хэрэгцээтэй ажил болно.



“ОЮУ ТОЛГОЙ” КОМПАНИ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ТОМООХОН ДЭД БҮТЦИЙГ ТӨРИЙН ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЛЭЭ

“Оюу толгой” ХХК өөрийн санхүүжилтээр барьсан Өмнөговь аймаг дахь “Оюу толгой” уурхайн цогцолбороос Монгол улс болон БНХАУ-ын хил хүртэл 96 км үргэлжилсэн цахилгаан дамжуулах агаарын шугамыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн өмчлөлд шилжүүлэх, ашиглалт засвар үйлчилгээг хариуцах хоёр гэрээнд 10 дугаар сарын 19-нд гарын үсэг зурлаа.

Гарын үсэг зурах ёслолд Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Занданхүү, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, Засгийн газрын албаны хүмүүс болон Рио Тинто группийн Монгол дахь суурин төлөөлөгч С.Мөнхсүх, “Оюу толгой” ХХК-ийн Санхүү хариуцсан захирал Стив Дугган нар оролцсон юм. Энэ үеэр “Оюу толгой” ХХК-ийн Санхүү хариуцсан захирал Стив Дугган “Бид Монгол улсын Засгийн газарт өндөр чанартай дэд бүтцийн байгууламжийг шилжүүлэн өгч, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буйдаа баяртай байна. Өнөөдрийн үйл явдал нь үр ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх компанийн стратеги бодитоор хэрэгжиж буйн нотолгоо боллоо. Цахилгаан дамжуулах агаарын шугам нь зөвхөн Оюу толгой

төдийгүй, бүс нутгийн хөгжлийн хурдасгуур юм” хэмээн хэллээ.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт “Өнөөдөр Монгол Улсын эрчим хүчний салбарт чухал өдөр тохиож байна. Уг шугамыг шилжүүлэн авснаар манай улсын эрчим хүчний сүлжээ найдвартай, өндөр чанартай дэд бүтцээр хөрш хоёр орны эрчим хүчний сүлжээнд холбогдож, дотоодын эрчим хүчний найдвартай байдлыг хангахын сацуу урт хугацаанд цахилгаан эрчим хүч экспортлогч орон болох зорилтыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. “Эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ”-ний дагуу бид “Оюу толгой” компанитай хамтран Өмнийн говийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай сүлжээнд холбох стратеги бодит ажил хэрэг болох нөхцөл бүрдэж байна” гэлээ.

Оюу толгой уурхайн үйл ажиллагааг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор дээрх шугамыг 2011 онд барьсан бөгөөд 2012 оны 7 дугаар сараас ашиглаж эхэлсэн юм. Өнгөрсөн хоёр жил гаруй хугацаанд цахилгаан дамжуулах шугам 100 хувь бүрэн хүчин чадлаараа ажиллаж, найдвартай байдал нь 99.8 хувьд хүрчээ.



НООСОН ЭДЛЭЛ УРЛАГЧ



Тэмээний ноосоор төрөл бүрийн бүтээгдэхүүн урлаж, зах зээлд нийлүүлдэг малчинтай уулзлаа. Энэ бол Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Хар заг багийн малчин Б.Гэрэлтуяа юм. Түүний бүтээгдэхүүнүүд сүлжмэл хувцас, гэрийн оосор бүч, малын ногт, бурантаг гэх мэтийн хэрэгсэл, эсгийгээр урласан бэлэг дурсгалын зүйлс гээд олон нэр төрөлтэй. Малаа маллахын зэрэгцээ гэрээрээ үйлдвэрлэл явуулдаг аж. Бүтээгдэхүүнээ орон нутагтаа борлуулахаас гадна аймаг, суманд болдог үзэсгэлэн худалдаанд оролцдог байна. Хүмүүс ч нэлээд сонирхож, худалдаж авдаг байна.

Тэрээр “Хүмүүс говь нутагт хамгийн элбэг байдаг тэмээний ноосоо ашигладаггүй.

Өнөөдөр уламжлалт аргаараа ч боловсруулахгүй байна. Зарим нь мартсан, зарим нь ч мэддэггүй байх. Цөөн тооны настай хүмүүс л малын хэрэгсэл хийж байгаа харагддаг. Манай ах, дүү нар бас надтай адил төрөл хувцас хийдэг” хэмээн ярилаа. Тэмээний нэг кг ноосыг зах зээлд 3500 төгрөгөөр, харин нэг ээрүүл утсыг 5000 төгрөгөөр борлуулна. Нэг ээрүүл утсанд 60 гр ноос ордог гэхээр илүү ашигтай. Бас бүтээгдэхүүн хийгээд зарвал дахин өртөг нэмэгдэнэ.

Б.Гэрэлтуяа “Манайх жилд 400 орчим кг ноос тэмээнээсээ авдаг. Бүтээгдэхүүн хийх ноосоо шилж үлдээгээд бусдыг нь зах зээлд борлуулчихна. Ноосон утсаа уламжлалт гар аргаар ээрч байгаа. Манай ээж Ц.Цолмон одоо 83 настай. Гэртээ зүгээр суухгүй, утас ээрдэг. Хийгээд сурчихсан ажил нь юм даа” гэлээ.

Түүний бүтээгдэхүүнүүд энэ жил Өмнөговь аймагт болсон “Говь фестиваль-2015” үзэсгэлэн худалдааны “Оёдол, гар урлалын шилдэг бүтээгдэхүүн” төрөлд тэргүүлж, Ханбогд суманд болсон бүсийн “Зах зээлийн өдөрлөг-Үзэсгэлэн худалдаа”-наас “Тэмээний шилдэг бүтээгдэхүүн”-ээр шалгарсан нь түүний амжилтыг илтгэнэ.

АЛБАН ХААГЧИД ӨРСӨЛДӨВ

Манлай сумын ИТХ, ЗДТГ хамтран төрийн албан хаагчдын санал, санаачилгыг сонсож, тэдний эв нэгдэл, хамтын ажиллагааг идэвхжүүлж, дэмжих зорилготой “Түмний амьдрал Таны манлайллаас” уриан дор “Төрийн албан хаагчийн зөвлөгөөн 2015” арга хэмжээг 10 дугаар сарын 23, 24-нд зохион байгууллаа. Зөвлөгөөнд сумын төсөвт байгууллагын нийт албан хаагчид буюу 126 хүн таван багт хуваагдаж, илтгэл, лекц, хэлэлцүүлэг, спорт, урлагийн арга хэмжээгээр өрсөлдсөн юм. Багийн нийт оноогоор Тэмүүлэл баг тэргүүлж, Манлайлагч баг удааллаа.



Энэхүү арга хэмжээг сумын төрийн албан хаагчдын дунд анх удаа зохион байгуулсан бөгөөд төрийн байгууллагын нийт албан хаагчдыг хамарч, бүх үйл ажиллагаа цагтаа эхэлсэн зэрэг олон онцлогтой байлаа.

ТОМУУГААС СЭРГИЙЛЦГЭЭ!

Мэдээллийг бэлтгэсэн СОС эмнэлэг



Томуу гэж юу вэ?

Томуу нь influenza вирусээр үүсгэгддэг бөгөөд амьсгалын замыг (хамар, залгиур, уушиг) өвчлүүлдэг. Энэ нь ихэнх тохиолдолд энгийн ханиад болон бусад амьсгалын замын вируст халдвараас илүү хүндээр өвчлүүлж, амь насанд аюултай хүндрэлүүд бий болгодог. Хөгшид, жирэмсэн эхчүүд, бага насны хүүхдүүд зэрэг нь томуугаар хүндрэх эрсдэл ихтэй. Томуугаас сэргийлэх хамгийн сайн арга нь жил бүр томуугийн вакцин хийлгэх. Томуугийн вакцин нь тухайн жилд дэгдэх магадлалтай вирусээс хамгаална. Томуугийн вакциныг 6 сараас дээш настай бүх хүн жил бүр хийлгэх хэрэгтэй. Вакциныг 10 дугаар сард хийлгэвэл хамгийн тохиромжтой бөгөөд 14 хоногийн дараа дархлаа тогтдог.

Томуугийн ямар шинж тэмдгүүд байдаг вэ?

Томуугийн үед илрэх түгээмэл шинжүүд бол халуурах, чичрүүдэс хүрэх, ядрах, булчин, үе мөч өвдөх, хоолой өвдөх, толгой өвдөх зэрэг юм. Томуугаар өвдсөн хүн бүр халуурахгүй. Томуу нь хөнгөн хэлбэрээс эхлэн илүү хүндээр өвчлүүлдэг бөгөөд үхэлд ч хүргэж болзошгүй. Энэ өвчин ихэвчлэн гэнэт илэрдэг. Монголд томуугийн улирал хэзээ байдаг вэ? Монголд томуугийн улирал намар, өвөл тохиодог.

Томуу хэрхэн дамждаг вэ?

Томуу дамждаг гол зам нь томуугаар өвдсөн

хүнээс ханиах, найтаах зэрэгт агаар дуслын замаар бусдад дамжина.

Өнгөрсөн жил томуугаар өвдсөн, томуугийн вакцин хийлгэсэн бол энэ жил томуугийн эсрэг дархлаатай байгаа юу?

Томуугийн улирлуудад хийгдсэн хэд хэдэн судалгаанаас харахад хүний томуугийн вирусийн эсрэг үүссэн эсрэг бие вакцин хийлгэсэн эсвэл өвдсөнөөс хойш ойролцоогоор нэг жилийн дараа ялангуяа хөгшин хүмүүсд буурдаг байна. Тиймээс өмнөх жилд нь томуугийн вакцин хийлгэсэн эсвэл өвдсөн бол дараа жил нь хангалттай дархлаатай байж чадахгүй. Иймд томуугаас хамгаалах хамгийн сайн арга нь өнгөрсөн жил томуугаар өвдсөн эсвэл вакцин хийлгэсэн үл хамааран жил бүр вакцин хийлгэх хэрэгтэй.

Томуугаар өвдсөн хүн хэр удаан халдвартай байдаг вэ?

Ихэвчлэн насанд хүрэгчид томуугийн шинж тэмдэг илрэхээс нэг хоногийн өмнөөс эхлэн өвдсөнөөс хойшхи 5-7 хоногийн хугацаанд бусдад халдаадаг. Харин хүүхдүүд 14 орчим хоногийн хугацаанд халдвар тараадаг. Шинж тэмдгүүд халдвар авснаас хойш 1-4 хоногийн дараа илэрч эхэлнэ.

Гэдэсний ханиад томуу мөн үү?

Олон хүмүүс дотор муухайрах, бөөлжих, суулгах зэргээр илэрдэг өвчнийг “Гэдэсний ханиад” гэж нэрлэдэг. Эдгээр шинж тэмдгүүд нь олон

тооны өөр өөр вирус, нян эсвэл шимэгчдээр үүсгэгдэнэ. Зарим тохиолдолд хүүхдүүдэд томуутэй холбоотой бөөлжих, суулгах, дотор муухайрах шинжүүд илэрдэг бөгөөд эдгээр нь томуугийн ховор тохиолдох шинжүүд юм. Томуу нь амьсгалын замын өвчин бөгөөд хоол боловсруулах замын өвчин биш юм.

Вакцин хийлгэхээс гадна томуугаас ямар аргаар сэргийлэх вэ?

Өдөр бүр халдвар тархахаас урьдчилан сэргийлэх алхмуудыг хэрэгжүүл.

- Өвдсөн хүнтэй шууд хүрэлцэхээс зайлхий.
- Өвчилсөн бол аль болох бусадтай уулзахгүй байх.
- Хэрэв та томуу төст өвчнөөр өвдсөн бол зөвлөмжийн дагуу халууралт бууртал хамгийн багадаа 24 цаг гэртээ байх хэрэгтэй. Таны халууралт 24 цагийн дотор өөрөө буух болно.
- Ханиаж найтаах үедээ ам, хамраа сальфеткаар дар.
- Гараа савандаж угаа. Хэрэв савандаж угаах боломжгүй бол спиртэн суурьтай гар ариутгагч хэрэглэ.
- Гараараа нүд, хамар, амандаа хүрэхээс зайлхий. Халдвар энэ замаар дамждаг.
- Халдварлагдаж болохуйц эд зүйлсийн гадаргууг цэвэрлэж ариутга.

МЯНГАТ МАЛЧНЫД ДӨРӨӨ МУЛТЛАХАД...



Өмнийн говьд сайхан зун өнгөрч, налгар намар залгажээ. Хориод хоногийн өмнө Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын малчин О.Авирмэдийнд буухад гүүгээ саагаад, айргаа эсгээд зунаараа угтлаа. Гэрийн эзэд малч, ажилсаг хүмүүс юм. О.Авирмэд эхнэрийнхээ хамт 1000 гаруй мал малладаг аж. Тэрээр анх 1973 онд эвлэлийн илгээлтээр хөдөө гарч гурван жил ажиллаад, цэргийн албанд мордсон байна. Цэргээс халагдаад нэгдлийн туслах мужаан болжээ. Нэлээд хэдэн жил ажиллаж байтал зах зээлд шилжиж, нэгдэл ч тарах нь тэр. Ингээд 1998 онд 128 ямаа, 26 хоньтой хөдөө гарсан байна. “Өсөх мал төлөөсөө” гэдэг. Ажилсаг эздийнхээ хичээл зүтгэлээр сүргийн тоо толгой жилээс жилд өсч, 2013 онд мянгат малчин болжээ. О.Авирмэдийнх одоо 900 гаруй бог, 100 гаруй адуутай. Тэрээр “Манайх тэмээтэй байсан. Ер нь олон төрлийн мал маллахад хүн хүч дутагддаг юм билээ. Одоо адуугаа ч дийлэхгүй болох

гээд байна” хэмээн ярьж байв. Энэ жил 34 гүү унагалжээ. Хэдийгээр гурван азарга адуутай ч хурдан морь уядаггүй, энэ их ажлын хажуугаар цаг зав ч гарахгүй юм гэж байсан. Туслах малчингүй, бүх ажлаа өөрсдөө хийдэг гэхээр үнэхээр ч зав гардаггүй биз. Хүүхдүүд нь бүгд тусдаа гарч, зарим нь хот суурин газар, зарим нь гадаадад амьдарч байгаа аж. Малчдын хувьд хамгийн хүнд улирал нь хавар. Эднийх малаа төллүүлэхдээ ч өөрсдөө болгочихдог гэж байна. Харин ямаагаа самнахдаа хүмүүсээс тусалцаа авдаг байна.

Биднийг адуу мал, айраг ярих завсарт гэрийн эзэгтэй С.Наймаахүү “Энэ жил айрагны гүйлгээ муухан байна. Өдөрт 100 гаруй литр саам гарна. Аймгийн төв рүү хүнээр дайж, бага багаар борлуулж байгаа” гэж өгүүлнэ лээ.

О.Авирмэд гарын уртай нэгэн. Их ажлынхаа хажуугаар уран бүтээлээ ч орхисонгүй. Чулуу, эвэр гээд төрөл бүрийн материалаар хөөрөгнөөс эхлээд бэлэг дурсгалын зүйлс урлана. Өнгөрсөн зун зав муутай байсан болохоор хийсэн цөөхөн хэдэн урлалынхаа заримыг нь сумынхаа музейд өгч, үлдсэнийг нь жуулчны газрууд нь руу явуулсан байна. Түүний олон жилийн өмнө урласан сийлбэрүүд сумын музейнээс эхлээд айлуудад өнөөдрийг хүртэл байдаг аж. Тэрээр “Манай сумын соёл урлагийн гурав хоног 1983 онд боллоо. Тэгтэл сумаас 10 морин хуурын хүсэлт ирж, тэрийг нь хийлээ. Одоо ч зарим

айлд зураг нь харагддаг юм. Дараа нь Номгон суманд 10 хуур хийж өгсөн. Захиалга өгсөн хүмүүс нь ирж хуурдаж үзээд гоё болсон байна гээд аваад явлаа. Үүний дараахан нэрт морин хуурч И.Цогбадрах манай суманд ирэхэд мастер хуурыг нь үзэж, тэр хүнээс нэлээд зөвлөгөө авсан юм. Түүнээс хойш морин хуураа гайгүй сайн хийдэг болсон доо” хэмээн хуучиллаа.

“Оюу толгой” компаниас өнгөрсөн жил эднийд энгийн гар худаг гаргаж өгчээ. Ус нь үргэлж тунгалаг байдаг, ундарга сайтай худаг аж. Налих багийн Хашаатын худгаа өөрийнхөө нэр дээр данслуулж, арчилж хамгаалдаг байна. Нэгэнт зардал мөнгөөр гаргасан худаг эзэнтэй байх нь чухал. Зарим хүн мод чулуугаар дүүргэх, тагийг нь онгорхой орхих гээд асуудал бий гэж О.Авирмэд ярьж байлаа.

Сүүлийн үед малчид малынхаа тооноос чанарт нь илүү анхаарах болжээ. Үүнийг О.Авирмэдийн ярианаас ч бас сонслоо. Эдний ямааны ихэнх нь Сүхбаатар аймгийн Баяндэлгэрийн улаан. Энэ омгийн ямааны ноолуурын гарц өндөр биш, дунджаар эм ямаанаас 500-600 гр, эр ямаанаас 700 гр ноолуур гардаг. Гэхдээ цагаан цайвар өнгөтэй, нарийн микронтой ноолуур нь хаана ч гологдохгүй, өндөр үнэ хүрнэ. О.Авирмэд “Хүмүүс нэг ямаанаас кг ноолуур авах гээд чанарыг нь муутгаад байна. Муу ноолуурыг үйлдвэрүүд голоод авахгүй шүү дээ. Манайх чанарыг нь л хардаг. Нэг хэсэг малаа 500-600 орчимд

барьсан. Одоо ч малаа ус, бэлчээр, хүн хүчдээ тохируулах шаардлага гарч л байна” гэлээ. Ганцхан ямаагаа ч биш хониныхоо ашиг шимийг нэмэгдүүлж, Сүхбаатар аймгийн “Үзэмчин” үүлдрийн хээлтүүлэгчтэй болжээ. Мах сайтай, сүүл томтой энэ хонийг малчид их сонирхдог байна.

Малчид малынхаа ашиг шимээс гадна өөр орлого олох боломж судалж, хайгаад эхэлжээ. О.Авирмэдийн хувьд жуулчдад хөтчөөр явж байсан тул энэ ажлыг сонирхож, “Оюу толгой” компаниас зохион байгуулсан орон нутгийн аялал жуулчлал эрхлэх хүсэлтэй иргэдэд зориулсан сургалтад суун, туршлага судлах аяллаар БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Авгын хошууны Бэлгүүдэйн цогцолбор, Чингис богд уул, Эрээн хотын үлэг гүрвэлийн музей зэрэг газруудтай танилцсан байна.

Тэрээр “Уг нь манай нутагт аялал жуулчлал хөгжих боломжтой. Нүүдэлчдийн айраг цагаа эсгэх, адуу мал саах, үрс хийх гээд ахуй амьдралтай танилцуулж, байгалийн сайхан, ан амьтдыг харуулж болно. Жуулчин авах гэж байгаа хүмүүс чинь өөрсдөө жуулчин болоод бид хоёр саяхан Швед улс яваад ирлээ” хэмээн ярианы завсар өгүүлнэ лээ.

Говийн мянгат малчныд үдлэх зууртаа бид ийн хөөрөлдлөө. Буцах замд ийм малчид л зах зээлийн нийгэмдээ зохицож, амьдрал ахуйгаа авч явдаг байх даа гэсэн бодол төрснийг ч дурдах хэрэгтэй биз ээ.

УЛАМЖЛАЛТ УРЛАЛААСАА СУРАЛЦАВ



Говийн уран бүтээлч эмэгтэйчүүдийг дэмжих “Дэлгэрэх ухаан” ТББ-ынхан Ханбогд сумын иргэдэд зориулан 10 дугаар сарын 22-27-нд “Үнэтэй даалингийн үнэгүй сургалт” зохион байгууллаа. Сургалтыг тус байгууллагын тэргүүн уран хатгамалч багш Ц.Цэцэгдэлгэр, удирдах зөвлөлийн гишүүн Л.Ашигчулуун нар явуулж, загасан нуруу хатгах, хөөрөгний даалин эмжих зэрэг уламжлалт урлалд 26 хүн суралцсан байна.

Энэ арга хэмжээ мартагдаж буй эдгээр урлалыг ард иргэдэд түгээн дэлгэрүүлэх, сургах, мөн хөөрөгний даалин урлаж, өөрсдийн хэрэгцээг хангахаас гадна зах зээлд борлуулж, өрхийн

орлогоо нэмэгдүүлэхэд нь туслах зорилготой юм.

“Дэлгэрэх ухаан” ТББ 2015 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулснаас хойш 230 гаруй иргэнд “Үнэтэй даалингийн үнэгүй сургалт” явуулжээ. Мөн үндэсний дээл, европ хувцасны загвар гаргах сургалтад 87, зээгт наамал, уран хатгамлын сургалтад 128 хүн хамруулсан байна.

Үүний зэрэгцээ англи хэлний сургалт зохион байгуулж, 300 иргэн оролцжээ. Эдгээр сургалтаа Даланзадгад, Ханбогд, Манлай, Цогтцэций, Булган зэрэг сумуудад явуулсан аж.

Дашрамд өгүүлэхэд Монгол эрчүүдийн гоёл буюу гангарааны нэгэнд даалин ордог. Хөөрөг агуулах торгомсог эдээр хийсэн уутыг даалин хэмээн нэрлэх бөгөөд хэмжээгээр нь бага, дунд, их гарын гэж ангилдаг. Голдуу торгон дээр зүү ороож урладаг энэ эдлэл түүхийн урт хугацаанд урлагийн бүтээл болон хөгжсөн байна.



Орон нутгаас ирүүлсэн санал, гомдол ба хүсэлт

2015 оны 10 – р сар (9-р сарын 25 – 10-р сарын 23)

(Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сум)

Санал, гомдол: Орон нутгаас санал, гомдол хүлээн аваагүй.

Хүсэлт: Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нийтдээ 17 хүсэлт хүлээн авсан бөгөөд эдгээрээс 5 хүсэлтэд холбогдох асуудлыг судлан шийдвэрлэж хариуг өгөөд байна. Хүсэлтүүдийн ихэнх хувийг дэмжлэг туслалцаа, хандив хүссэн хүсэлт эзэлжээ. Харин үлдсэн хувийг уурхайн талбайд зочлох, байгаль орчин/цооног/худаг, бусад/мэдээлэл хүссэн, хамтран ажиллах тухай хүсэлтүүд байв. Хариу өгөгдөөгүй байгаа хүсэлтүүдийн дагуу зохих ажлуудыг зохион байгуулж, шийдвэрлэхээр ажиллаж байна.



Санал, гомдол, хүсэлтийг: Соёлын өв, байгаль орчин, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хангамж, хандив тусламж, хүний эрх, барилга бүтээн байгуулалт/гэрээтүүд, хүний нөөц, олон давтан гаргасан болон бусад гэсэн төрлүүдээр бүртгэдэг.

“Оюу толгой” компанитай холбоотой асуудлаар otcommunities@ot.mn хаягаар эсвэл 9903 4732 (Оюу толгой уурхай), 9509 0391 (Ханбогд сумын оффис), 95091907 (Манлай сумын оффис), 9909 8406 (Даланзадгад сумын оффис) руу холбогдоно уу. Санал, гомдлын маягтыг дээрх оффисуудаас авч болно.

Д.БАДАМХАНД: 2000 ГАРУЙ КМ ЯВЖ, 22673 МАЛ УГААЛАА

“Оюу толгой” компанийн Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрөөс бүс нутагт малын эрүүл ахуйг сайжруулах, орон нутагт байгуулагдсан хоршоодыг бэхжүүлэх зорилгоор Ханбогд сумын хоршоодын дунд “Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах” төсөл шалгаруулж, санхүүжүүлэх уралдаан зарласан юм. Энэхүү төсөлд “Баян саглар”, “Их ногоон гурвалжин”, “Төрлийн мянган тайж” хоршоо шалгарч, ажлаа гүйцэтгэсэн байна. Эдний нэг болох “Баян саглар” хоршооны малын эмч Д.Бадамхандтай ярилцлаа.



- **Танай хоршоо ямар төсөл бичиж шалгарсан бэ?**

- Малын угаалга хийх төсөл бичиж, шалгарсан

байгаа. Төслийн санхүүжилтээр тоног төхөөрөмж, бодисоо авч, бензин, шатахууны бусад зардлаа гаргасан. Маш өгөөжтэй төсөл болсон учраас сэтгэл хангалуун байна. Би өнгөрсөн зун 7 дугаар сарын 30-наас 8 дугаар сарын 24 хүртэл 2000 гаруй км явж, 22673 мал угаалаа. Манай мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хэсэгт Номгон багийн 25, Баян багийн 25, Гавилууд багийн 12 малчин өрх байдаг. Энэ айлуудын мал угаалганд бүрэн хамрагдсан. Ганц нэг айл хоцорсон тал бий. Айлын тавиул мал олон болохоор татгалзсан гэсэн.

- **Ямар байдлаар, ямар үнээр угаадаг вэ. Дээр үед ванн хийгээд мал бүрийг оруулж угаадаг байсан?**

- Бүх малыг шүршиж угаасан. Говийн нөхцөлд усны асуудал бэрхшээлтэй. Айлуудын өвөлжөө дээр ус байдаг. Гэтэл тэнд ванн хийж, олон мал байлгаж болохгүй. Тиймээс УАЗ 469 машинд чиргүүл чирээд, уусмалтай сав, мотороо ачаад яваад байлаа. Айлуудын бууцан дээр угаагаад явсан. Зөвхөн усаа зөөхдөө ирэх, очих хоёр талдаа 20 гаруй км явах, олон малтай айл байвал хэд хэдэн удаа явах гээд бэрхшээл гарч байсан. Гэхдээ бүх ажлаа төлөвлөсний дагуу бүгдийг нь хийлээ. Манай аймгийн ИТХ-аар нэг малыг

400 төгрөгөөр угаана гэж тогтоосон байдаг. Бидний хувьд 200 төгрөгөөр угаалаа.

- **Яагаад ийм үнэ тогтоосон юм бэ. Малчид малаа угаалгахын ач тусыг ойлгож байна уу?**

- Малчид их сайхан ажил боллоо гэж байсан. Угаалга хийснээр мал паразит өвчнөөс сална. Малд угаалга, туулгалт маш чухал. “Эрүүл малаас эрүүл хүнс” гэдэг шүү дээ. Нөгөө талаар бид маш хямд үйлчилгээ үзүүлсэн. “Оюу толгой” компани хоршоод, мал эмнэлгийг дэмжиж, санхүүжүүлсэн учраас нэг малыг 200 төгрөгөөр угаасан. Өнөөдөр ийм үнэ хаана ч байхгүй.

- **Яагаад бууцан дээр нь угаадаг вэ?**

- Бууцаа давхар ариутгаж, халдваргүйжүүлж байгаа хэрэг. Хэрвээ бууц хороо ариун бол мал ширхэгтэж, бөөсдөхгүй. Хүн усанд орчихоод хиртэй хөгжилд унтдаггүйтэй адил.

- **Цаашид ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ?**

- Туулгалт хийхээр төлөвлөсөн. Саяхан манай суманд малчдын зөвлөгөөн боллоо. Тэнд очиж, малчдаас санал авсан байгаа.

СУРАГЧИД УСНЫ ЧАНАРТ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ БАЙНА

“Оюу толгой” компаниас орон нутагт олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүний нэг бол Өмнөговь аймгийн Даланзадгад, Манлай, Ханбогд, Баян-Овоо суманд 2012 оноос хэрэгжүүлж буй “Сурагчидтай хамтарсан усны чанарын хяналт үнэлгээ” төсөл юм. Төслийн хүрээнд эдгээр сумуудын сурагчид оршин суугаа орон нутгийнхаа булгийн усанд хяналт, үнэлгээ хийх, хяналтын үр дүнд олж авсан мэдээллээ олон нийтэд хүргэх, үүгээр дамжуулж хамгаалах ажил зохион байгуулах юм.

Энэхүү төслөөр сурагчдыг сургаж дадлагуулан, бие даан төслийн үйл ажиллагаанд оролцох боломж олгодог бөгөөд хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гарган санал боловсруулан хэрэгжүүлдэг онцлогтой. Өнгөрсөн 2014 онд багш, сурагчдыг давтан сургаж дадлагуулан, шаардлагатай багаж хэрэгслээр хангасан юм. Мөн 18 багш, 35 сурагч булгийн усны чанарт хяналт үнэлгээ хийх мэдлэг чадварыг зуслангийн сургалтаар эзэмшиж, олж авсан мэдлэг чадвараа ашиглан өөрсдийн орон нутагт байгаа булгийн усанд хяналт үнэлгээ

хийж, үнэлгээнийхээ дүнг нээлттэй өдөрлөгөөр дамжуулан 700 гаруй хүнд мэдээлэл өгчээ. Харин 2015 онд төслийн хүрээнд гурван үндсэн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд одоогийн байдлаар хоёрыг нь хэрэгжүүлээд байна.


1. Усны чанарт үнэлгээ хийх ажилд 7 сургуулийн 157 сурагч, 12 багш, эцэг, эхийн болон ахмад багш нарын төлөөлөл оролцож, усны чанарыг физик, хими, биологийн аргаар хяналт хийснээр тухайн усан орчныг хамгаалах дараах санал санаачилгуудыг гаргасан юм. Үүнд: Усны ойр орчмын хогийг түүж цэвэрлэн хогийн цэгт хүргэх, булгийн усан дундуур гарсан авто машины замыг хаах, мэдээлэл хүргэх самбар байрлуулах, булгийн эхийг хашиж, хогийн сав тавих, олон нийтэд мэдээлэл хүргэх, мэдлэг олгох ажлууд зохион байгуулах зэрэг болно.
2. Усан орчныг хамгаалах талаар гаргасан дээрх саналын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Даланзадгад сумын дөрвөн сургуулийн сурагчид Говь гурвансайхан уулын Ёлын ам, Шатын ам, Хавцгайт, Дүнгэнээгийн булаг, Манлай сумын

сурагчид Баянбулаг, Ханбогд сумын сурагчид Их булаг, Баян-Овоо сумын сургуулийн сурагчид Хуруугийн булаг орчмын хогийг түүж төвлөрсөн хогийн цэгт хүргэснээс гадна самбар, санамжууд, хогийн савыг хийж байрлууллаа.

Мөн Хуруугийн булгийн усыг laidан шуудуулж хайс хийлээ. Ихбулгийн усны хашлага хайсны унасан шонг босгон, хугарсан шонг сольж, мод тарихад зориулж торон хашаа бариад байна. Усан орчныг хамгаалах ажилд сурагчид, эцэг, эхчүүд, сумуудын байгаль орчны мэргэжилтнүүд, багш нар, булгийн ойр орчим нутагладаг малчид зэрэг 70 гаруй хүн оролцлоо.

Усны чанарын хяналт, үнэлгээний дүнг олон нийтэд хүргэх, тэднийг дээрх үйл ажиллагаанд татан оролцуулах, усан орчныг хамгаалах санал санаачилгыг шийдвэр гаргагчдад хүргэх нээлттэй өдөрлөгийг сургууль тус бүр зохион байгуулахаар бэлтгэж байна. Өдөрлөг угтаж сурагчдын дунд өөрийн сургуулийн хяналт, үнэлгээ хийдэг булгийг хэрхэн хамгаалах тухай эссе бичих, гар зургийн уралдаан, нэрэмжит спортын уралдаан тэмцээнүүд зарласнаас гадна хийсэн хяналт, үнэлгээний дүнг цахимд оруулж, CD-д буулгаж, олон нийтэд мэдээлэл түгээхээр бэлтгэж байна.

Өмнөговь аймгийн Скаутын зөвлөлийн дарга П.Оюунчимээ





“Галбын говь залуусын дуранд” гэрэлзургийн уралдаан

Гэрэл зургийн удирдамж:

Ханбогд сумын малчидтай хамтарсан “Зэрлэг амьтны ажиглалт, тооллого” төсөл болон “Залуучуудын хөгжлийн төв” хамтран гэрэл зураг авах сонирхолтой хүүхэд, өсвөр үеийнхний дунд гэрэл зургийн уралдаан зарлаж байна.

Гэрэл зурагт тавигдах шаардлага:

- Уралдааны нэр, агуулгад нийцсэн байх
- Зургийн чанарт тавих ямар нэг шаардлага байхгүй (зураг авдаг бүхий л хэрэгслийг ашиглаж болно)
- Гэрэл зураг нь зэрлэг амьтан, ургамал, байгалийн үзэмжит төрх байдал, үзэгдэл зэргийг харуулсан байна.
- Зураг нь тухайн оролцогчийн өөрийн өмч байх

Гэрэл зураг илгээхдээ анхаарах зүйл:

Гэрэл зургийг 11 дүгээр сарын 25-ныг дуусах хүртэлх хугацаанд Munkhbayarno@ot.mn цахим шуудангийн хаягаар хүлээн авна. Гэрэл зураг илгээгч нь өөрийн овог, нэр, фейсбүүк хэрэглэгчийн нэр, и-мэйл хаяг болон утасны дугаараа зургийн хамт илгээнэ. Түүнчилэн зургийн файлын нэрийг өөрийн овог нэрээр сольж, нэгээс дээш зураг явуулах бол дугаарлана уу.

(Эдгээр мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд шалгаруулалтанд оролцох боломжгүй)



УУРХАЙН ТАЛБАЙД МОД ТАРИЛАА

“Оюу толгой” компанийн үндсэн болон гэрээт ажилтнууд “Мод тарих үндэсний өдөр” буюу 10 дугаар сарын 10-нд уурхайн талбайд ногоон байгууламж байгуулах ажил хийлээ. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн

тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан билээ.

Энэ өдрийг тохиолдуулан “Оюу толгой” компанийн хамт олон тав дахь жилдээ ийнхүү мод тарьсан байна. Бүх нийтээр мод тарих ажил жилээс жилд өргөжиж, Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо, Хүрмэн сум болон Даланзадгад хотын айл өрх, аж ахуйн нэгжүүд идэвхитэй оролцох болжээ.

Дашрамд өгүүлэхэд өнгөрсөн хаврын мод тарих өдрөөр эдгээр сумуудад 26222 ширхэг мод, сөөгний тарьц, суулгац тарьсан юм.



Зөвлөмж

Мод, сөөг тариалж буй хүмүүс дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.

- Мод, сөөг суулгахын өмнө тарих нүхийг урьдчилан ухаж бэлтгэн, нүхийг усаар дүүргэж, чийгийн хангамжийг сайжруулах нь зүйтэй. Түүнчлэн мод тарихад хэрэглэх шимт шороо, элс, хонины бууц, хүрз, шуудай, хувин зэрэг багаж хэрэгсэл, ус зэргээ бэлэн болгож, бэлтгэл ажлаа хангасан байх шаардлагатай.
- Мод, сөөгний нүхийг 60-80 см-ийн голчтой, 50-60 см-ийн гүнтэй ухна. Үржил шимтэй өнгөн шороог нүхний нэг талд, доод талын үржил шимгүй шороог нүхний нөгөө талд

тус тусад нь овоолно. Өнгөн шороог нүхэндээ эргүүлж хийх бөгөөд үржил шимгүй шороогоор нүхний амсар дээр тогоо хийнэ.

- Бэлдсэн чийгтэй хөрсний гол хэсэгт модныхоо үндсийг тараан байрлуулж, шороогоор хучиж, нягтруулан агаар орохооргүй чигжиж өгнө.
- Тарьсан модны үндэс нугалараагүй шулуун, үндэсний үзүүр доош чиглэсэн байх ёстой. Тарьж байгаа модыг нүхний ёроолд хэтэрхий гүнд суулгаж болохгүй.
- Тарьсан өдөртөө багтааж модыг 50-60 литр, сөөгийг 20-30 литр усаар нүхнийхээ ханыг дагуулан усална.

Редактор Ч.Батпүрэв

Мэдээллийг бэлтгэсэн: Б.Батбилэг,
Б.Танхилдулам, Ж.Мөнгөндолгоо,
Н.Хэрлэнтуул

Гэрэл зургийг: Э.Идэрбаатар, А.Хатан-Оол,
Н.Мөнхбаяр

Зохион байгуулагч: Н.Сосорбурам

Хэвлэлийн эхийг: Г.Мандах-Оргил

Та бүхэн “Орон нутгийн сонин”-той холбоотой санал хүсэлтээ Улаанбаатар хот болон Ханбогд сум дахь Орон нутгийн харилцааны ажилтнаар дамжуулан бидэнд илгээгээрэй.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мөнхис Цамхаг, 1 давхар, Утас: 976-11-331880, Факс: 976-11-331885

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Цагаан булагийн 8-р баг, “Оюу толгой” ХХК-ийн Өмнөговь дахь Төлөөлөгчийн газар
Утас: 976-7053-3961, 976-7053-3963
Факс: 976-11-331890

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Иргэдийн хөгжлийн төв, “Оюу толгой” ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн салбар
Утас: 976-331880 (5316)
976-331880 (7647)

Дэлгэрэнгүй мэдээллийг ot.mn цахим хуудаснаас авна уу.